


Сүүлийн хоёр жилийн хугацаанд мөнгөний зөөлөн бодлогын нөлөөгөөр хувьцааны үнэ ихээхэн өссөнийг бид дэлхийн топ индексүүд бүх цаг үеийн дээд түвшинд хүрснээс харж болно. Тэгвэл 2020 оноос хойш хэрэгжиж ирсэн мөнгөний зөөлөн бодлогын төгсгөл ирж байгаа нь хөрөнгийн зах зээлд нөлөөлөгч гол хүчин зүйл болоод байна. Дотоодын болон олон улсын зах зээл дээр хувьцааны ханш, хүү, валютын ханш, түүхий эдийн үнэ хэрхэн өөрчлөгдөж байгаа болон цаашдын хандлагын талаар уг тоймд тусгалаа.

ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

- 2021 оны 12-р сард улсын инфляц 13.4% болж, 2015 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрлээ.
- Төрөөс хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн төлбөрийг дахин 6 сараар хойшлууллаа.
- Монголын Хөрөнгийн Биржийн Топ-20 индекс 41,913 нэгжид хүрч энэ оны эхнээс -5.6 хувиар унаад байна. Топ-20 индексэд багтдаг хувьцаат компаниудын нийт үнэлгээ Монголын Хөрөнгийн Захын нийт үнэлгээний 71 хувийг эзэлдэг.
- Топ-20 индексээс Хөвсгөл Алтан Дуулга ХК хасагдаж Талх Чихэр ХК нэмэгдлээ. Уг өөрчлөлтийг 1-р сарын 25-ны өдрөөс мөрдөж эхэлнэ.
- Биржийн бус зах зээл нь үнэт цаас гаргагчийн цаг хугацаа, зардлыг хэмнэж, богино хугацаанд санхүүжилт татах, нэгэн талбар бөгөөд 2021 оны 8-р сард уг зах зээл дээр анхны бонд гарч байсан. Өнөөдрийн байдлаар бонд гаргах замаар биржийн бус зах зээлээс нийт 298.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татжээ. Төгрөгийн бондуудын хувьд 9%-16%-ийн хүүтэй байгаа бол ам.долларын бонд 6.8% хүүтэй байна.

Индексүүдийн хөдөлгөөн (оны эхнээс)




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Топ-20 индексийн хувьцаануудаас 6 хувьцааны ханш оны эхнээс өсөлттэй байгаа бол бусад 14 хувьцааны ханш уналттай арилжаалагдаж байна. Өсөлтөөрөө MNDL, UID, MFC хувьцаанууд тэргүүлж байгаа бол APU, MNP, AARD, GOV, ADB, AIC, SUU, NEH хувьцаанууд хамгийн өндөр уналтыг үзүүлээд байна.

	APU	MNP	AARD	INV	TTL	ERDN	GOV	BODI	ADB	LEND	MNDL	AIC	SUU	TUM	UID	MFC	MMX	BDS	ADU	NEH
1/21/2022	1697	1268	8380	4022	7415	907.68	287.08	148.17	204.12	39.2	122.43	1144	550.23	640.91	4103	118.98	3500	1200	560	25.52
MTD %	-6%	-6%	-14%	-1%	-2%	0%	-12%	-4%	-7%	-3%	26%	-13%	-7%	-5%	9%	5%	1%	1%	2%	-7%
MoM%	-5%	3%	-7%	22%	0%	0%	-14%	4%	-5%	-2%	26%	-18%	-29%	-2%	24%	5%	-1%	14%	2%	-6%
YoY%	182%	76%	202%	37%	5%	-6%	32%	18%	143%	26%	154%	39%	166%	258%	174%	78%	23%	41%	-7%	72%

АПУ ХК



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

АПУ ХК нь Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 31 хувийг дангаараа бүрдүүлдэг билээ. АПУ ХК хувьцааны үнэ өмнөх жилийн мөн үеэс 175.7 хувиар өссөн шалтгаан нь гадаад орнуудад хийх экспортын дүн үлэмж хэмжээгээр нэмэгдсэн явдал юм. 2021 онд ОХУ дахь борлуулалтаа 2 дахин, БНХАУ дахь борлуулалтаа 6 дахин өсгөсөн ба цаашид экспортын хэмжээгээ тэлэх зорилгоор Япон, Солонгос, Европын холбооны улсуудын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах туршилтын үйл ажиллагаа эхлүүлээд байна.


Үнэт цаасны нэр	Нэгж үнэ	Нийт үнийн дүн
АПУ ХК	1,650	250,001,400
Ард санхүүгийн нэгдэл ХК	8,500	300,007,500
Даваанбулаг ХК	227	392,641,446
АПУ ХК	1,600	1,423,715,200
АПУ ХК	1,600	250,000,000
Мандал Даатгал ХК	84	1,127,270,541
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	9,000	499,995,000
АПУ ХК	1,600	250,000,000
Мандал Даатгал ХК	91	546,000,000
Тэнгэрлиг медиа групп ХК	15,000	385,815,000
Шивээ овоо ХК	2,200	613,712,000
Шивээ овоо ХК	2,200	613,714,200
Бодь Даатгал ХК	150	1,000,000,050

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2021 оны 12-р сараас 2022 оны 1-р сарын 21-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 13 удаагийн багцын арилжаагаар явагдаж, нийт 7.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Багцын арилжааг өндөр дүнтэй хэлцэл хийх зорилгоор хэрэглэдэг ба томоохон хөрөнгө оруулагч нар тухайн хувьцааг хэдээр үнэлж авч байгааг харах нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тус болдог. Жишээ нь: АПУ ХК дээр 2.2 тэрбум төгрөгийн хэлцэл багцын арилжаагаар хийгдсэн ба нэгж хувьцааны жигнэсэн дундаж үнэ 1,606 төгрөг байна.


2021 оны эцсийн байдлаар М2 мөнгөний нийлүүлэлт ₮27.8 их наяд хүрч өмнөх оноос 15%-р өссөн байна. Цар тахлын үеийн мөнгөний зөөлөн бодлого болон засгийн газрын цар тахалтай тэмцэх ₮10 их наядын бодлого уг өсөлтөд томоохон нөлөө үзүүлжээ.

М2 мөнгөний нийлүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

Банкуудын шинээр татсан хадгаламжийн хүү




Эх сурвалж: Монголбанк

2021 оны 12-р сарын тоо мэдээнээс харвал шинээр татсан 10-12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн хүү 8.3% буюу өмнөх сараас 0.7%-р буурсан. Харин гадаад валютын хадгаламжийн хүү 6.2%-д хүрч өмнөх сараас огцом өссөн буюу 3.7%-иар өсжээ. Монголбанкны бодлогын хүү бага байгаа, мөнгөний нийлүүлэлт их байгаа зэрэг суурь хүчин зүйлээс шалтгаалан төгрөгийн хадгаламжийн хүү буурсаар байна. Харин 12-р сард гаргасан Монголбанкны мөнгөний бодлогын шийдвэрт банкуудын гадаад валютын заавал байлгах нөөцийг нэмэгдүүлсэн нь ам.долларын хадгаламжийн хүүнд

огцом өөрчлөлт оруулсан мэт харагдаж байна. Өөрөөр хэлбэл гадаад валютын заавал байлгах нөөцийн шаардлагыг хангахын тулд банкууд гадаад валютын хадгаламжийг хүү үл харгалзан татах шаардлага тулгарсан болов уу. Макро эдийн засгийн ерөнхий хандлагаас зөрүүтэй үйл явдал тул гадаад валютын хадгаламжийн хүүгийн өсөлтийг түр зуурын шинжтэй гэж үзэж байна.

Төв банкны үнэт цаасны хэмжээ




Эх сурвалж: Монголбанк

Төв банкны үнэт цаасыг (ТБҮЦ) зөвхөн арилжааны банкууд эзэмшдэг бөгөөд банкуудын хувьд сул чөлөөт мөнгөн хөрөнгөө байршуулах гол хэрэгсэл нь юм. Нөгөө талаас ТБҮЦ-ийн хэмжээг банкуудын сул чөлөөт төгрөгийн дүнг баримжаалахад ашиглаж болно. Графикаас харвал 2020 оны эхэн үеэс 2.2 дахин их ТБҮЦ банкны системд байна. Өөрөөр хэлбэл банкууд мөнгөний илүүдэлтэй байгаа бөгөөд хадгаламжийг өндөр хүүгээр татах сонирхолгүй байгаа нь хадгаламж болон зээлийн хүү нам дор түвшинд тогтвортой байх шалтгаан болж байна.

ТБҮЦ нь мөн хүү өсөх урьдач дохио болох боломжтой бөгөөд систем дэх ТБҮЦ хэмжээ огцом буурч эхэлбэл хүү өсөх сигнал гэж үзэж болно.


Гадаад худалдааны тэнцэл



Эх сурвалж: Монголбанк

2021 оны гадаад худалдааны ашиг \$2.4 тэрбумд хүрсэн нь бүх цаг үеийн хамгийн өндөр дүн юм. Экспортын гол нэр төрлийн барааны экспортын хэмжээ буурсан хэдий ч түүхий эдийн үнийн өсөлтийн ачаар Монгол улсын гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2021 онд экспортын үнийн дүнгээрээ зэсийн баяжмал \$2.9 тэрбумаар тэргүүлсэн бол коксжих нүүрс \$2.76 тэрбумаар удаалжээ.

БНХАУ коксжих нүүрсний импорт



■ БНХАУ коксжих нүүрсний нийт импорт
● БНХАУ нийт импортод эзлэх Монголын экспортын хэмжээ

Эх сурвалж: Блүүмбэрг

2021 онд БНХАУ-ын нийт коксжих нүүрсний импортын хэмжээ 18 сая тонн буюу 25%-р буурсан байна. Харин Монгол улсын коксжих нүүрсний экспорт 9.7 сая тонн буюу 41%-р буурчээ. Ингэснээр БНХАУ-ын коксжих нүүрсний зах зээлд Монгол улсын эзлэх хэмжээ 33%-с 26% болж буурсан бол нөгөө талд гол ялагчид нь АНУ, Канад, ОХУ нар байлаа. Бас нэгэн муу мэдээ байгаа нь БНХАУ улс 2021 оны 4-р улиралд Австрали улсаас коксжих нүүрс авч эхэлсэн нь манай улсын өрсөлдөх чадварт томоохон сөрөг нөлөөг үзүүлэх эрсдэлтэй. Хилээр нүүрс тээвэрлэхэд үүсээд буй гол асуудал нь Ковид19 халдвар хамгааллын асуудал бөгөөд чингэлгээр экспортлох

чадамжаа нэмэх, төмөр замаа яаралтай ашиглалтад оруулах нь нэн чухал байна. БНХАУ зүгээс 2022 ондоо хилийн хатуу дэглэмээ үргэлжлүүлэх магадлал тун өндөр байгаа.

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Хөрөнгийн зах зээл: 2022 он гарснаас хойш гурван 7 хоногийн дотор S&P 500 индекс 6 гаруй хувиар, Nasdaq индекс 7.55 хувиар унасан нь цар тахлаас хойших хамгийн өндөр уналт болоод байна. Шалтгаан нь инфляц, мөнгөний хатуу бодлого, цар тахлын үеийн бодлогын өөрчлөлт.

Хүү: АНУ-ын Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ өсгөж эхэл нь тодорхой болсон нь мөнгөний хатуу бодлогын эхлэл болж байна. Хатуу бодлого нь компаниудын ашигт ажиллагаа болон үнэлгээнд сөрөг нөлөөтэй үзүүлдэг тул хөрөнгийн зах зээл нийтээрээ уналттай байна. Дэлхийн томоохон төв банкууд ихэнх нь инфляцийн өсөлтөөс шалтгаалан мөнгөний зөөлөн бодлогоос хатуу бодлогод шинжиж байна. Харин БНХАУ эсрэгээрээ бодлогын хүүгээ бууруулж, эдийн засгийн өсөлтөө дэмжиж эхлээд байгаа нь томоохон бодлогын зөрүүтэй байдлыг үүсгээд байна.

Түүхий эдийн зах зээл: Түүхий эдийн үнэ ханш өсөлттэй байгаа бөгөөд богино хугацаандаа БНХАУ-ын эдийн засгаа дэмжих бодлогын нөлөө, урт хугацаандаа дэлхийн дулаарлын эсрэг тэмцэл зэрэг нь эерэг нөлөө үзүүлж байна. Тэр дундаа газрын тосны үнэ 2014 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрсэн бөгөөд хэрэглэгч улс орнуудын хувьд инфляцийн өсөлтөд томоохон нөлөө үзүүлж байна.

01/23/22)	Индексийн өгөөж			
	Үнэ цэнэ	5 өдөр	1 сар	1 жил
DJIA	34,265.37	-4.58%	-4.69%	10.54%
S&P 500	4,397.94	-5.68%	-6.94%	14.49%
Nasdaq	13,768.92	-7.55%	-12.04%	1.67%
Nikkei 225	27,522.26	-2.14%	-4.38%	-3.87%
Hang Seng	24,965.55	2.39%	7.50%	-15.22%
Shanghai	3,522.57	0.04%	-2.64%	-2.33%
STOXX50	4,230	-1.00%	-0.60%	17.41%

Эх сурвалж: Блүүмбэрг

БНХАУ-ын төв банкны зүгээс мөнгөний бодлогоо зөөлрүүлэн бодлогын хүүгээ 10 нэгжээр бууруулан 2.85 хувьд хүргэсэн нь 2020 оны 4 сараас хойших хамгийн анхны тохиолдол юм. Хятадын засгийн газрын зүгээс хямралд ороод буй үл хөдлөхийн салбарт дэмжлэг үзүүлэх тухайгаа мөн мэдэгдсэнээр Shanghai болон Hang Seng индекс өсөлттэй арилжаалагдаж байна.



Техник шинжилгээнээс харвал SP500 индекс нь 2020 оны 3-р сараас хойш үргэлжилсэн өсөлтийн дэмжих шугамыг доош сэтгэлсэн байдалтай байна. Өнгөрсөн онд тус индексийн уналт болгоныг худалдаж авах боломж гэж үзэж байсан бол энэ удаагийн уналт өөр бололтой. Учир нь өнгөрсөн хугацаанд хувьцааны зах зээлийг өсгөж байсан мөнгөний бодлого нь одоо 180 градус эргэж эхэлж байна.

АНУ 10 жилийн хугацаатай ЗГ бондын өгөөж



Эх сурвалж: Блүүмбэрг

АНУ-ын 10 жилийн хугацаатай ЗГ-ын бондын өгөөж 1.5 хувиас 1.9 хувь хүртэл өссөн нь сүүлийн 2 жилийн хамгийн дээд түвшин юм. ХНС нь цар тахлын үед хэрэгжүүлж байсан бонд худалдаж авах хөтөлбөрөө дуусгавар болгох, 2022 ондоо бодлогын хүүгээ өсгөж эхлэх, цаашлаад худалдаж авсан бондоо зах зээлд эргүүлэн зарж эхлэх хүлээлтүүд үүсээд байна.

АНУ



Эх сурвалж: Блүүмбэрг

АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн (ХНС) мөнгөний бодлогод инфляц болон ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр нөлөөтэй. Жилийн инфляцыг 2%-д онилдог бол 2021 оны эцсийн байдлаар 7%-д хүрээд байна. Харин ажилгүйдлийн түвшин цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрч буурсан нь ХНС-д бодлогын хүүгээ өсгөх ногоон гэрлийг асаагаад өглөө. 2022 ондоо 3-4 удаа хүүгээ өсгөхөөс гадна мөнгөний нийлүүлэлтийг хумьж эхлэх хүлээлт зах зээлд үүсээд байна.

		Forecast		
		2021	2022	2023
Real GDP (YoY%)	World	5.9%	4.3%	3.6%
	US	5.6%	3.8%	2.5%
	China	8.1%	5.2%	5.3%
CPI (YoY%)	World	4.3%	4.1%	2.8%
	US	4.7%	4.6%	2.4%
	China	0.9%	2.2%	2.2%

Эх сурвалж: Блүүмбэрг

Дэлхийн тээвэрлэлтийн үнийн индексээс харвал тээврийн үнэ хөлс нь цар тахлын өмнөх үеэс 6-7 дахин өссөн харагдаж байна. Дэлхий даяар үүсээд буй өндөр инфляцыг нийлүүлэлтийн гаралтай гэж дүгнэж байгаа. Тэгвэл тус нийлүүлэлтийн гаралтай инфляцын томоохон хэсгийн тээврийн үнэ хөлс бүрдүүлсэн байна. Сайн мэдээ гэвэл тээврийн үнийн өсөлт намжсан харагдаж байгаа бөгөөд БНХАУ-с бусад улсын хувьд харьцангуй өөдрөг хүлээлттэй байна.

	Алт	Газрын тос (Brent)	Зэс	Коксжих нүүрс (Австралийн марк)	Төмрийн хүдэр
1/21/2022	1835.38	87.89	9941	408.33	136.99
MoM%	0%	13%	2%	19%	15%
YTD%	3%	19%	4%	21%	12%
YoY%	-1%	59%	24%	246%	-19%

Эх сурвалж: Блүүмбэрг


АНУ-ын хөрөнгийн зах зээл нийтээрээ унаж байгаа хэдий ч эдийн засгийн салбар бүр дэхь хөдөлгөөн харилцан адилгүй байдаг. Уналтаараа Технологи, Харилцаа холбоо болон Тогтмол бус хэрэглээний сектор тэргүүлж байгаа бол Өргөн хэрэглээ, Нийтийн хэрэглээ, Санхүү, Аж үйлдвэрийн салбарууд харьцангуй бага уналттай байна. Эндээс эдийн засгийн салбар бүрийн эрсдэлийн хэмжээг харж болж байна. Технологи, харилцаа холбоо зэрэг нь хамгийн өндөр эрсдэлтэй салбар бол өргөн хэрэглээ нь хамгийн эрсдэл багатай салбар байна. Мөн хөрөнгийн зах зээл уналттай үед хөрөнгө оруулагчид мөнгөө эрсдэл өндөртэй хувьцаанаас эрсдэл багатай хувьцаанд шилжүүлдгийг ажиглаж болно.

БНХАУ-ын ДНБ 2021 онд 8.1%-иар өссөн нь хүлээлтээс өндөр үр дүн хэдий ч БНХАУ-ы төв банкнаас бодлогын хүүгээ бууруулах арга хэмжээ авлаа. Учир нь ирэх онуудад ДНБ-ийн өсөлт нь жилд 5.2%-5.3% болж удаашрах төсөөлөлтэй байгаад оршино. БНХАУ-ын гаргасан вакцинууд нь Омикрон хувилбарын эсрэг маш бага нөлөө үзүүлж байгаа тул дотооддоо халдварын тархалтыг намжаах зорилгоор хөл хориог хэсэгчлэн тогтоож, хилийн хяналтаа чангатгаж байгаа зэрэг нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна.



Эх сурвалж: Блүүмбэрг

БНХАУ эдийн засгийн өсөлтөө дэмжихээр хүүгээ бууруулж эхэлсэн нь төмрийн хүдэр болон коксжих нүүрсний ханшид эерэгээр нөлөөлсөн ажээ. Дэлхий даяар цар тахлын хөл хорио дуусах, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх хүлээлт дээр үндэслэн газрын тосны үнэ өндөр өсөлттэй байлаа. ОПЕК-ын орнууд газрын тосны гарцаа аажмаар нэмэгдүүлж байгаа хэдий ч зарим улс орнуудын хувьд тохиролцсон хэмжээндээ хүрч гарцаа нэмэгдүүлж чадахгүй байна. Үүнээс үүдэн газрын тосны зах зээлд нийлүүлэлтийн хомстолд орж болзошгүй гэсэн айдас үүсээд буй.



Эх сурвалж: Блүүмбэрг

СТАТИСТИК ТОО МЭДЭЭ

Монголын макро эдийн засгийн үзүүлэлт

	Хэмжих нэгж	Last	2021 H1	2020 H2	2020 H1
ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2021Q3	Жилийн өөрчлөлтийн %	3.60%	6.3%	-4.6%	-9.0%
Хэрэглээний үнийн индекс 2021.12	Жилийн өөрчлөлтийн %	13.40%	6.6%	2.3%	2.8%
Гадаад валютын албан нөөц 2021.11	сая \$	4165.2	4732	4534	3556
Төлбөрийн тэнцэл (оны эхнээс өссөн дүнгээр) 2021.11	сая \$	-436.4	-54	787	-679
Гадаад худалдааны тэнцэл 2021.12	сая \$	2398.5	850	2282	368

Эх сурвалж: Монголбанк, Статистийн мэдээллийн нэгдсэн сан

Засгийн газрын бондын өгөөж

	01/21/2022	12/31/2021	2021 H1	2020 H2	2020 H1	2019 H2	2019 H1
АНУ 1 жил ЗГ бондын өгөөж	0.55%	0.38%	0.07%	0.11%	0.15%	1.58%	1.93%
Европ Холбоо 1 жил ЗГ бондын өгөөж	-0.65%	-0.66%	-0.64%	-0.67%	-0.53%	-0.61%	-0.62%
Япон 1 жил ЗГ бондын өгөөж	-0.116%	-0.1%	-0.12%	-0.13%	-0.20%	-0.13%	-0.21%
АНУ 10 жил ЗГ бондын өгөөж	1.76%	1.51%	1.47%	0.91%	0.66%	1.92%	2.01%
Европ Холбоо 10 жил ЗГ бондын өгөөж	-0.07%	-0.18%	-0.21%	-0.57%	-0.46%	-0.19%	-0.33%
Япон 10 жил ЗГ бондын өгөөж	0.132%	0.065%	0.05%	0.02%	0.02%	-0.02%	-0.16%

Эх сурвалж: Блүүмбэрг

Хувьцааны индекс

	ТОП20	MSCI World	S&P 500	NASDAQ	Dow Jones	Hang Seng	CSI300	Stoxx 50
1/21/2022	41913.49	3025.1	4397.94	13768.92	34265.37	24965.55	4779.31	4229.56
MTD%	-6%	-6%	-8%	-12%	-6%	7%	-3%	-2%
MoM%	-1%	-4%	-5%	-10%	-3%	9%	-3%	1%
YoY%	97%	10%	14%	2%	11%	-15%	-14%	17%

Эх сурвалж: Блүүмбэрг, Монголын Хөрөнгийн Бирж

Валютын ханш

	USDMNT	EURUSD	USDJPY	USDCNY
1/21/2022	2846.58	1.1344	113.68	6.3387
MTD%	0%	0%	-1%	0%
MoM%	0%	1%	0%	-1%
YoY%	0%	-7%	10%	-2%

Эх сурвалж: Блүүмбэрг

Түүхий эдийн үнэ

	Алт	Газрын тос (Brent)	Зэс	Коксжих нүүрс (Австралийн марк)	Төмрийн хүдэр
1/21/2022	1835.38	87.89	9941	408.33	136.99
MTD%	0%	13%	2%	19%	15%
MoM%	3%	19%	4%	21%	12%
YoY%	-1%	59%	24%	246%	-19%
2022 таамаглал*	1732	74.0	9347	249.5	95.5
2023 таамаглал*	1655	73.0	9375	180.7	85.0

* - шинжээчдийн таамаглалын дундаж бөгөөд өмнөх сарын Хөрөнгийн захын тоймын үеэс таамаглалын утга өссөн, буурсан эсэхийг өнгөөр ялгаж харуулсан.
Эх сурвалж: Блүүмбэрг

ТОГТМОЛ ӨГӨӨЖТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮТЭЭГДЭХҮҮН



16%

☎ Холбоо барих: 9935 5913 /Хөрөнгө оруулалтын зөвлөх/
9699 9993 /Хөрөнгө оруулалтын зөвлөх/

✉ info@ardsecurities.com

🌐 ardsecurities.com